



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 11 өдөр

Дугаар

А/МН7

Номгон

Аймгийн Төрийн байгууллагын дарга
нарын ажлын цаг ашиглалтын "Timely.mn"
системийг үргэлжлүүлэн
ашиглах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны "Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай" 03 дугаар албан даалгаврын 1.4, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1.Ажлын цаг ашиглалт, бүтээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд цаг бүртгэлийн "Timely.mn" нэгдсэн системээр нийт төрийн байгууллагын дарга, сумын Засаг дарга нарын ажлыг цагийг үргэлжлүүлэн бүртгэсүгэй.

2.Мэдээллийг "Timely.mn" системд бүртгэж, төрийн байгууллагын удирдах албан тушаалтнуудыг систем ашиглалтын зөвлөгөө, зааварчилгаагаар ханган, хяналт тавьж, өдөр тутмын мэдээ, мэдээллээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Отгонбаяр)-д, ажлын цагаа тогтмол бүртгүүлж ажиллахыг нийт сум, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

3.Систем хариуцагч байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулан, 2026 оны 03 дугаар сарын төлбөр болох 501,270 (Таван зуун нэг мянга хоёр зуун дал) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Отгонбаяр)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

626010527